



2021 оны 07 дугаар сарын 02  
№25 /1175/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦᠷᠢᠶᠢᠨ  
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ

ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠠᠨ

ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



## زینتکار

زینتکار میوه در کسب نامی در مسابقات

6996	7000	کشتن 90	میوه نامی در مسابقات	796
996	90	کشتن 90	میوه نامی در مسابقات	996
996	90	کشتن 90	میوه نامی در مسابقات	000

زینتکار میوه در مسابقات

696	700	کشتن 70	میوه نامی در مسابقات	600
696	70	کشتن 70	میوه نامی در مسابقات	700
706	700	کشتن 700	میوه نامی در مسابقات	700
706	900	کشتن 900	میوه نامی در مسابقات	900

زینتکار میوه در کسب نامی در مسابقات

906	70	کشتن 70	میوه نامی در مسابقات	100
-----	----	---------	----------------------	-----

زینتکار میوه در مسابقات

906	90	کشتن 90	میوه نامی در مسابقات	900
-----	----	---------	----------------------	-----



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

198.	Түр хороо байгуулах тухай	Дугаар 44	1691
199.	Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 06 дугаар дүгнэлтийн тухай	Дугаар 46	1694
200.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журам батлах тухай	Дугаар 47	1696

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

201.	Хошууч генерал цол хүртээх тухай	Дугаар 38	1707
202.	Цэргийн дээд цол хүртээх тухай	Дугаар 39	1707
203.	Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдэд зэрэг дэв олгох тухай	Дугаар 133	1708
204.	Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай	Дугаар 134	1708

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

205.	Журам батлах тухай	Дугаар 68	1709
------	--------------------	-----------	------

### МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

206.	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай	Дугаар 06	1714
------	--	-----------	------

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 05 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 44

Улаанбаатар  
хот

### Түр хороо байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэл Улаанбаатар хотын хөгжлийн асуудал эрхэлсэн түр хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### Түр хорооны дарга:

Э.Бат-Амгалан

Улсын Их Хурлын гишүүн

#### Түр хорооны гишүүд:

1/С.Амарсайхан

Улсын Их Хурлын гишүүн

2/Г.Амартүвшин

Улсын Их Хурлын гишүүн

3/П.Анужин

Улсын Их Хурлын гишүүн

4/Т.Аюурсайхан

Улсын Их Хурлын гишүүн

5/Х.Булгантуяа

Улсын Их Хурлын гишүүн

6/С.Бямбацогт

Улсын Их Хурлын гишүүн

7/Ж.Ганбаатар

Улсын Их Хурлын гишүүн

8/Х.Ганхуяг

Улсын Их Хурлын гишүүн

9/Т.Доржханд

Улсын Их Хурлын гишүүн

10/Б.Жаргалмаа

Улсын Их Хурлын гишүүн

11/Ц.Мөнх-Оргил

Улсын Их Хурлын гишүүн

12/Ц.Мөнхцэцэг

Улсын Их Хурлын гишүүн

13/Х.Нямбаатар

Улсын Их Хурлын гишүүн

14/С.Одонтуяа

Улсын Их Хурлын гишүүн

15/М.Оюунчимэг

Улсын Их Хурлын гишүүн

16/Ц.Сандаг-Очир

Улсын Их Хурлын гишүүн

17/Д.Сарангэрэл

Улсын Их Хурлын гишүүн

18/Б.Саранчимэг

Улсын Их Хурлын гишүүн

19/Ж.Сүхбаатар

Улсын Их Хурлын гишүүн

20/Н.Учрал

Улсын Их Хурлын гишүүн

21/Д.Цогтбаатар

Улсын Их Хурлын гишүүн

22/Ж.Чинбүрэн

Улсын Их Хурлын гишүүн

23/Б.Энхбаяр

Улсын Их Хурлын гишүүн.

2.Энэ тогтоолыг 2021 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**



09 / 06 . Үндэстний г  
 66 / 66 . Үндэс - үндэс  
 706 / 66 . Үндэс үндэс  
 706 / 0 . Үндэстэн  
 96 / 44 . Үндэстэн г  
 106 / Үнд . Үндэстэн  
 96 / 66 . Үндэстэн  
 26 / 44 . Үндэстэн  
 76 / 49 . Үндэстэн  
 36 / 44 . Үндэстэн  
 01 / 44 . Үндэс  
 61 / 44 . Үндэстэн  
 71 / 44 . Үндэстэн  
 11 / 44 . Үндэстэн

үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн  
 үндэстэн

• 7 үндэстэн г 6 0 0 1 6 үндэстэн 9 үндэстэн 6 - 6 үндэстэн үндэстэн үндэстэн ..

үндэстэн үндэстэн г  
 үндэстэн үндэстэн г  
 үндэстэн үндэстэн г



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 06 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 06 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.2.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд буюу Цэцийн аль нэг гишүүн эс зөвшөөрч гомдол, санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.” гэж заасны “... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.” гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**







## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 06 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журам батлах тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1993 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн 40 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

3.Энэ тогтоолыг 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

Монгол Улсын Их Хурлын 2021 оны  
06 дугаар сарын 17-ны өдрийн 47 дугаартай  
тогтоолын хавсралт

### **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЁСЛОЛЫН ЖУРАМ**

Монгол Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргасны дараа Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас товлон тогтоосон өдөр, цагт Монгол Улсын Их Хуралд Монгол Улсын Үндсэн хуулиар тогтоосон тангараг өргөнө.

#### **Нэг.Тангараг өргөх ёслолын бэлтгэл**

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд зориулан Д.Сүхбаатарын талбайд Төрийн далбаа мандуулсан байна.

2.Төрийн ордны “Их Монгол” танхим /цаашид “танхим” гэх/-ын тайзны гүнд хөх цэнхэр дэвсгэр дээр Монгол Улсын Төрийн сүлд залж, түүний баруун талд Монгол Улсын төрийн далбааг байрлуулсан байна.

Төрийн далбааны дэргэд ам дөрвөлжин цагаан эсгий дэвсэж, хоёр талд Монгол Улсын төрийн хүндэт харуул зогссон байна.

Танхимын тайзны баруун талд шинэ сонгогдсон Ерөнхийлөгч, бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч болон Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргад зориулсан ширээ, сандал, танхимын тайзны зүүн талд Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд болон Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргад зориулсан ширээ, сандал, танхимын тайзны голд шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөж, үг хэлэх индэр, тайзны зүүн, баруун жигүүрт Улсын Их Хурлын гишүүдийн суух сандлыг хивсэн дээр тус тус байрлуулсан байна.

3.Танхимын тайзны голд байрлуулсан индрийн дэргэд Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг байрлуулах тавцан, шинэ сонгогдсон Ерөнхийлөгчид зориулсан ширээн дээр Ерөнхийлөгчийн тангараг бичиг, гарын үсэг зурах үзэг болон бэх уусгагч тавьсан байна.

4.Тангаргийн хавтасны гадна нүүрний дээд хэсэгт Төрийн сүлдийг алтлаг өнгөөр дүрсэлж, шил талд нь “Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг” гэсэн үгийг монгол үсгээр, доод хэсэгт кирилл үсгээр тус тус дармалдсан байна. Хавтасны дотор талын эхний нүүрэнд “Алтан соёмбо” үсэг зурж, дараагийн нүүрэнд Ерөнхийлөгчийн тангаргийг монгол, кирилл үсгээр гүн хөх өнгөөр гоёмсог хэвлэсэн байна.

5.Танхимд Зэвсэгт хүчний Жанжин штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим байрласан байна.

6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгчид, Ерөнхий прокурор болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлага болон хэвлэл мэдээллийн ажилтнууд, иргэдийн төлөөлөл, гадаадын дипломат төлөөлөгчдийн газрын тэргүүн, зочдыг урьж оролцуулна.

### **Хоёр.Тангараг өргөх ёслол**

1.Төрийн ёслол хариуцсан нэгжийн ажилтан зарлан мэдэгдэхэд танхимын тайзны баруун талаас Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг Төрийн хүндэт харуулын хамгаалалт дор залж индрийн дэргэд тусгайлан бэлдсэн тавцанд байрлуулна.

2.Төрийн хүндэт харуул Их эзэн Чингис хааны хөшөөний өмнө ирж зогсоно.

3.Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч гэргий /нөхөр/-н хамт Төрийн ёслол хүндэтгэлийн “Өргөө” цогцолборын өмнө хүрэлцэн ирэхэд Төрийн ёслол хариуцсан нэгжийн дарга, Төрийн ордны хамгаалалтын албаны дарга угтан авна.

Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч гэргий /нөхөр/-н хамт Их эзэн Чингис хааны хөшөөнд мэхийн ёслоод Төрийн ёслол хүндэтгэлийн “Өргөө” цогцолборын баруун хаалгаар морилно.

4.Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын гишүүдийн ирцийг мэдэгдэж Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны ажиллагааг нээж “Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Их Хуралд тангараг өргөнө” хэмээн зарлан мэдэгдэнэ.

5.Ийнхүү зарламагц Ерөнхийлөгч Тамгын газрын даргыг, дараа нь шинэ сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслол хариуцсан нэгжийн даргыг дагуулан танхимын тайзнаа хүрэлцэн ирж, суудалдаа сууна. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Төрийн тамгыг залж бүрэн эрх нь дуусгавар болж байгаа Ерөнхийлөгчийн ширээнд байрлуулна. Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа Ерөнхийлөгч, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч монгол үндэсний хувцастай байна.

6.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны үед Төрийн тамгыг хамгаалах үүргийг Төрийн хүндэт харуулын дарга гүйцэтгэнэ.

7.Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч индэрт гарч Монгол Улсын Үндсэн хуулийн уг эх дээр баруун гараа тавиад тангаргийг цээжээр дээдлэн дуудаж, ширээнээ эргэн очиж тангараг бичигт гарын үсгээ зурж, Улсын Их Хурлын даргад тангараг бичгээ гардуулна. Ийнхүү тангараг бичгээ гардуулсны дараа Төрийн далбааны дэргэдэх ам дөрвөлжин цагаан эсгий дээр очиж, малгайгаа зүүн гартаа аван зүүн хөл урагш нэг алхаж баруун өвдөг сөгдөн Төрийн далбаанаас адис авна.

8.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөсний дараа Төрийн тамгыг хадаг /нанжвандан/ дээр залж, Монгол Улсын Ерөнхийлөгчид хүндэтгэлтэйгээр өргөн барина. Шинэ сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн тамгыг хүндэтгэлтэйгээр гардан авч, тэргүүнээ бөхийлгөн адис авч ширээн дээрээ зална.

9.Ерөнхийлөгчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд шинэ сонгогдсон Ерөнхийлөгч Төрийн ёслол хариуцсан нэгжийн даргыг дагуулан танхимын тайзнаа хүрэлцэн ирж өөрт нь зориулсан суудалд сууна.

10.Бүрэн эрх нь хугацаанаасаа өмнө дуусгавар болсон Ерөнхийлөгчийн оронд шинэ сонгогдсон Ерөнхийлөгчид Төрийн тамгыг Улсын Их Хурлын дарга энэ журмын Хоёрын 8 дахь заалтад заасны дагуу гардуулан өгнө.

11.Тангараг өргөсөн Ерөнхийлөгч Төрийн тамгыг ширээн дээрээ залмагц Улсын Их Хурлын дарга Ерөнхийлөгчид баяр хүргэж, хөгжимд Монгол Улсын Төрийн дуулал эгшиглэнэ. Төрийн дуулал эгшиглэж байхад ёслолын ажиллагаанд оролцож байгаа бүх хүн босож зогсоно.

12.Төрийн дуулал эгшиглэсний дараа иргэдийн төлөөлөл ахмад настан баяр хүргэж үг хэлж, хадаг, мөнгөн аягатай сүүг Ерөнхийлөгчид барина. Ерөнхийлөгч хадаг, мөнгөн аягатай сүүг хүлээж аваад Улсын Их Хурал болон ард түмэндээ хандаж индэрт үг хэлнэ. Ерөнхийлөгч үг хэлж дуусмагц Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа өндөрлөснийг мэдэгдэнэ.

13.Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон Ерөнхийлөгч Тамгын газрын дарга дагуулан Ерөнхийлөгчийн өргөөнд хүрэлцэн ирнэ. Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Төрийн тамгыг, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Монгол Улсын Үндсэн хуулийн уг эхийг Төрийн хүндэт харуулын хамгаалалт дор байранд нь буцаан зална.

14.Тангаргаа өргөсөн Ерөнхийлөгч Төрийн ёслол хүндэтгэлийн “Өргөө” цогцолбор дахь Монгол Улсын нэгдсэн тулгар төрийн уламжлалт өсөн хөлт Их цагаан туганд хүндэтгэн ёсолж адис авна.

### **Гурав.Цэргийн ёслолын жагсаал**

1.Зэвсэгт хүчний Жанжин штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим, Төрийн хүндэт харуул, цэргийн ёслолын жагсаалд оролцох бие бүрэлдэхүүн Д.Сүхбаатарын талбайд жагсана.

2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч Төрийн ёслол хариуцсан нэгжийн даргыг дагуулан Төрийн ёслол хүндэтгэлийн “Өргөө” цогцолборын зүүн хаалгаар гарч, тусгайлан зассан тавцан дээр зогсоно. Монгол Улсын Ерөнхийлөгчийн баруун хойд талд Батлан хамгаалахын сайд, зүүн хойд талд Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга зогсоно.

3.Цэргийн жагсаал командлагч Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид илтгэл өгнө. Монгол Улсын Ерөнхийлөгч нийт бие бүрэлдэхүүнтэй мэндчилнэ.



4.Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч нийт бие бүрэлдэхүүнд хандаж үг хэлнэ. Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлж дуусахад Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжим Төрийн дуулал эгшиглүүлнэ. Төрийн дуулал эгшиглэх үед ёслолын буудлага хийнэ.

5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолд зориулсан цэргийн ёслолын жагсаал явуулна.

### **Дөрөв.Монгол Улсын Ерөнхийлөгчийн ажил хүлээлцэх**

1.Монгол Улсын Ерөнхийлөгч өрөөндөө хүрэлцэн ирж ажил хүлээлцэнэ. Ажил хүлээлцэхэд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга байлцана.

### **Тав.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгчийг үдэх**

1.Төрийн хүндэт харуул үдэж гаргахаар жагссан байна.

2.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгч Төрийн ёслол хүндэтгэлийн “Өргөө” цогцолбор дахь Монгол Улсын нэгдсэн тулгар төрийн уламжлалт есөн хөлт Их цагаан туганд хүндэтгэн ёсолж адис авна.

3.Бүрэн эрх нь дуусгавар болсон Ерөнхийлөгчийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, Төрийн ёслол хариуцсан нэгжийн дарга, Төрийн ордны хамгаалалтын албаны дарга Төрийн ордны зүүн талын нуман хаалганы дотор талын талбайгаас үднэ.

### **Зургаа.Бусад**

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаа, цэргийн ёслолын жагсаалыг радио, телевиз, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр орон даяар шууд дамжуулна.

2.Монгол Улсын Ерөнхийлөгчид Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд бараалхаж баяр хүргэнэ.

3.Гадаадын зочин, төлөөлөгчид Монгол Улсын Ерөнхийлөгчид бараалхаж баяр хүргэх ёслолыг Төрийн ёслол хариуцсан нэгж, Гадаад харилцааны яамны Дипломат ёслол хариуцсан нэгж хамтран зохион байгуулна.

4.Монгол Улсын Ерөнхийлөгч тангараг өргөсөнтэй холбогдуулан хүндэтгэлийн урлагийн тоглолт, дайллага, үндэсний бөхийн барилдааныг зохион байгуулж болно.

















## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 38

Улаанбаатар  
хот

### Хошууч генерал цол хүртээх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 37 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Бригадын генерал Гомбожавын Ариунбуян, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч, Бригадын генерал Бужийновын Амгаланбаатар, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч, Бригадын генерал Очирын Энхбаяр нарт Хошууч генерал цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2021 оны 03 дугаар  
сарын 18-ны өдөр

Дугаар 39

Улаанбаатар  
хот

### Цэргийн дээд цол хүртээх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 37 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурандаа Дагвадоржийн Ганхуяг, ЗХЖШ-ын Нэгдүгээр орлогч дарга, хурандаа Цэвэлмаагийн Жавхланбаатар, Дотоодын цэргийн штабын дарга, хурандаа Сийлээгийн Ганбат, Хил хамгаалах ерөнхий газрын Ар тал, зэвсэглэл, инженер техник эрхэлсэн дэд дарга, хурандаа Дашдондогийн Ганбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дэд дарга, хурандаа Батмөнхийн Ууганбаяр, ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, хурандаа Маждаагийн Мөнхбаяр, Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлагч, хурандаа Балжидийн Баатар, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлагч, хурандаа Дашцэдэнгийн Баасандамба, Зэвсэгт



хүчний Агаарын цэргийн штабын дарга, хурандаа Батсуурийн Эрдэнэбат, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга, хурандаа Дамдинсүрэнгийн Дамдинцэрэн нарт Бригадын генерал цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2021 оны 05 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар  
хот

**Хүний эрхийн Үндэсний Комиссын  
гишүүдэд зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Монгол Улсын Их Хурлын 2001 оны 50 дугаар тогтоолоор батлагдсан “Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Жаргалсайханы Хунан, Хүрэлбаатарын Мөнхзул, Дугарын Сүнжид, Ганбатын Нарантуяа, Батзэвэгийн Энхболд нарт Дэд түшээ зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2021 оны 05 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 134

Улаанбаатар  
хот

**Төрийн захиргааны албан тушаалын  
зэрэг дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын тэргүүн түшмэлийн зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН  
БАТТУЛГА**



Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны  
05 дугаар сарын 28-ны өдрийн 134 дугаар  
зарлигийн хавсралт

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ  
ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧ

№	Овог, нэр	Эрхэлж буй ажил	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1	Ядамын Хишигт	Төрийн албаны зөвлөлийн Хүний нөөцийн удирдлага, аудитын газрын дарга	АА-3	Дөтгөөр зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 03 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 68

Улаанбаатар  
хот

**Журам батлах тухай**

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.2-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх журмын хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Ашигт малтмал, газрын тосны газар (Х.Хэрлэн)-т, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндонд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Л.ОЮУН-ЭРДЭНЭ**

**УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

**Г.ЁНДОН**



Засгийн газрын 2021 оны 68 дугаар  
тогтоолын хавсралт

## **ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛСЫН НӨӨЦ БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний хомстол үүсч үнийн хөөрөгдөл гарахаас урьдчилан сэргийлэх, эдийн засгийг тогтвортой хөгжүүлэх нөхцөлийг хангах зорилгоор Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.2-т заасны дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, түүнийг хадгалах, зарцуулах, нөхөн бүрдүүлэх, сэлгэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.2.Тус журмыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага, газрын тосны бүтээгдэхүүний импорт, үйлдвэрлэл, бөөний худалдаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүд дагаж мөрдөнө.

### **Хоёр.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх**

2.1.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь газрын тосны бүтээгдэхүүний үнийн өсөлтийг сааруулах, хангамжийн тасалдал, хомстол үүсэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор бүрдүүлэх газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээ, төсвийн талаарх саналыг боловсруулж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

2.2.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, түүнийг зарцуулах, нөхөн бүрдүүлэх нэр төрөл, тоо хэмжээ, үнийн асуудлыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

2.3.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Засгийн газраас тогтоосон нэр төрөл, тоо хэмжээгээр газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг бүрдүүлэх, худалдан авахтай холбогдсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ улсын болон хувийн эзэмшлийн агуулах бүхий тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж (цаашид “хадгалагч” гэх)-тэй “Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээ”-г байгуулж хадгалуулна.

2.4.Энэ журмын 2.3-т заасан гэрээнд бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар стандарт, байршил, хадгалах хугацаа, талуудын хүлээх

үүрэг, хариуцлага, хяналт, мэдээ тайлан ирүүлэх болон бусад нөхцөлийн талаар тодорхой тусгана. Гэрээний үлгэрчилсэн загвар болон сэлгэн хадгалалттай холбоотой мэдээ, тайлангийн маягтыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

2.5.Улсын нөөц бүрдүүлэх зориулалтаар газрын тосны бүтээгдэхүүн худалдан авахтай холбоотой зардлыг улсын төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

### **Гурав.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хадгалах**

3.1.Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу хадгалагч нь газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг сэлгэн хадгалах гэрээнд заасан нөхцөл, шаардлагын дагуу хүлээн авч өөрийн эзэмшлийн стандартын шаардлага хангасан зориулалтын агуулахад хадгална.

3.2.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн зориулалтаар хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүний чанар, стандартын хэвийн байдлыг хангах зорилгоор сэлгэх ажлыг зохион байгуулж болно.

3.3.Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээ, шаардлага, зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан Засгийн газраас тогтоосон нийт үнийн дүнд дүйцүүлэн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн нэр төрөл, тоо хэмжээг хооронд нь Засгийн газрын шийдвэрээр шилжүүлж болно.

3.4.Хадгалагч аж ахуйн нэгж нь өөрийн эзэмшлийн агуулахад хадгалж байгаа газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн бүтээгдэхүүнийг сэлгэх аж ахуйн нэгжээр сонгогдох давуу эрх эдэлнэ.

3.5.Газрын тосны бүтээгдэхүүний хадгалагчид газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хүлээлгэн өгөхдөө хүлээлгэн өгсөн тухай баримтыг 4 (дөрөв) хувь үйлдэх бөгөөд энэ баримт нь газрын тосны бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, стандартыг тодорхой заасан, хүлээлгэн өгсөн огноо, талуудын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байна. Баримтын 1 хувийг Төрийн захиргааны байгууллагын албан хэрэгцээнд, 1 хувийг Төрийн захиргааны байгууллагын архивд, 1 хувийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт, 1 хувийг тухайн бүтээгдэхүүн хадгалагчид тус тус хадгалуулна.



3.6. Хадгалагч нь гэрээнд заасан эрх, үүргээ бусдад шилжүүлэхгүй, эрх бүхий холбогдох байгууллагын шийдвэргүйгээр газрын тосны нөөцийн бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ, чанар, байршлыг өөрчлөхгүй, нөөцийг өөр зорилгоор ашиглахгүй, зарцуулахгүй байх үүрэг хүлээнэ.

### **Дөрөв.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг зарцуулах**

4.1. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5.1.4-т заасан нөхцөл байдал үүсч, төрөөс зохицуулалт хийх зайлшгүй нөхцөл байдалд хүрсэн тохиолдолд үнийн өсөлтийг сааруулах, хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцөөс зарцуулах нэр төрөл, тоо хэмжээ зэргийг Засгийн газар шийдвэрлэнэ.

4.2. Засгийн газрын шийдвэрийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцөөс зарцуулах, худалдах үйл ажиллагааг газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зохион байгуулна.

4.3. Хадгалагч нь өөрийн эзэмшлийн агуулахад хадгалагдаж байгаа газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцөөс Засгийн газрын тогтоосон үнээр эхний ээлжид худалдан авах давуу эрх эдэлнэ.

4.4. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг худалдан авагч нь бүтээгдэхүүний төлбөрийг гэрээ байгуулснаас хойш хуанлийн 14 хоногийн дотор Төрийн сангийн дансанд шилжүүлнэ. Гэрээнд заасан хугацаа хэтэрсэн хоног тутам худалдан авагч нь гэрээний үнийн дүнгийн 0.5 хувиар алданги төлөх бөгөөд төлбөрийг бүрэн барагдуулж дууссаны дараа худалдан авагч захиран зарцуулах эрхтэй.

4.5. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг худалдан авсан үнэ, холбогдон гарсан зардлаас бага үнээр төрд алдагдал үүсгэх байдлаар Засгийн газрын шийдвэргүйгээр худалдан борлуулахыг хориглоно.

4.6. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг худалдан борлуулсан орлогыг зөвхөн газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг нөхөн бүрдүүлэхэд зарцуулна.

### **Тав.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг нөхөн бүрдүүлэх**

5.1. Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцөөс зарцуулсан хэсгийг нөхөн бүрдүүлэхдээ тухайн үеийн газрын тосны бүтээгдэхүүний

үнэ, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлсэн саналд үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

5.2.Засгийн газрын шийдвэрийн дагуу газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцөөс зарцуулсан хэсгийг нөхөн бүрдүүлэх үйл ажиллагааг газрын тосны бүтээгдэхүүний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

### **Зургаа.Тайлагнах, хяналт тавих**

6.1.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хадгалагч нь улсын нөөцийн бүтээгдэхүүний сэлгэн хадгалалттай холбоотой мэдээ, тайланг батлагдсан маягтын дагуу сар бүрийн 5-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор үнэн, зөв гаргаж газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

6.2.Газрын тосны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийг хадгалагчаас ирүүлсэн мэдээ, тайланг нэгтгэн сар бүрийн 15-ны өдрийн дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн дотор газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлнэ.

6.3.Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөцийн мэдээ, борлуулалтын тайлан, нөөцийн үлдэгдлийн балансыг жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.4.Газрын тосны бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэх үйл ажиллагаанд Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасны дагуу мэргэжлийн хяналтын байгууллага, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрх хэмжээний хүрээнд тус тус хяналт тавьж ажиллана.

### **Долоо.Хариуцлага**

7.1.Хадгалагч нь энэ журам, гэрээнд заасан үүргийг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээх ба учирсан хохирлыг нөхөн төлнө.

7.2.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2021 оны 05 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 06

Улаанбаатар  
хот

### **Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай**

Үндсэн хуулийн цэцийн  
хуралдааны танхим 11.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Одбаяр даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Солонго, Г.Туулхүү, Ш.Солонго, Г.Баясгалан /илтгэгч/ нарын бүрэлдэхүүнтэй, хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Баяржаргалыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

### ***Нэг. Монгол Улсын иргэн Б.Мөнхзаяа Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан мэдээлэлдээ:***

“... Үндсэн хуулийн цэцийн гишүүн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гагцхүү Үндсэн хуульд захирагдаж, аливаа маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах бөгөөд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнээс маргаан хянан шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.” гэж заасан билээ.

Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль болон органик хуульд тодорхой заасан байхад Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд аль нэг гишүүн нь Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа

үүсэх эсэх тухай ижил тэнцүү эрхтэй бусад гишүүний гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч, санал гаргах нь тухайн шийдвэр гаргасан гишүүнээс маргаан хянан шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож, шахалт дарамт үзүүлж, бусад хэлбэрээр нөлөөлж байгаа хэрэг юм.

Үүнээс гадна Үндсэн хуулийн цэцийн аль нэг гишүүн аливаа нэг улс төрийн нам, төрийн өндөр албан тушаалтнууд, улс төрчид, төдийгүй хөрөнгөлөг аж ахуйн нэгж, гадаад улсын тусгай албад, олон улсын төрийн болон төрийн бус бусад байгууллагын нөлөөнд автаж, Үндсэн хуулийн цэцийн өөр нэг гишүүнийхээ үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлж, улс орны эрх ашгийг умартах нөхцөл байдлыг бүрдүүлж, тусгаар тогтнол, аюулгүй байдалд хор уршиг тарих эрсдэлийг бий болгохыг ч үгүйсгэх аргагүй юм. Үүний зэрэгцээ хуульд заасан энэхүү зохицуулалтаар бий болох “3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаан” нь зохион байгуулалтын талаасаа өргөдөл, мэдээлэл гаргагчийн гомдлоор хуралддаг Бага суудлын хуралдаанаас зарчмын хувьд өөр хэлбэртэй бөгөөд хэрхэн зохион байгуулж, хуралдах талаар хууль болон Үндсэн хуульд дурдах нь зүйтэй байна.

Ийнхүү нэг гишүүн санал гаргах нь ашиг сонирхол, авлига, албан тушаалын хэрэгт сэрдэгдэх нэг нөхцөл бөгөөд ийм байдалд орохыг үгүйсгэхгүй юм. Ийм байдлаар нэг гишүүнийхээ шийдвэрт өөр нэг гишүүн нь “хориг” тавих хэлбэрээр санал бичгээр гаргах нь цаашид хэвийн үзэгдэл болж, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа алдагдахад хүргэх хор уршигтай. Үндсэн хуулийн цэцийн зохион байгуулалтын хэлбэр нь гагцхүү шат шатны хуралдаан бөгөөд нэг гишүүн нь нөгөө гишүүний гаргасан шийдвэрийг ганцаараа үгүйсгэн, улмаар хэрхэн хуралдах тухай дэг нь хуульд заагаагүй “3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаан” гэгчээр хэлэлцэх нь уг байгууллагын хамтын шийдвэр гаргадаг хууль ёсны зохион байгуулалтыг эвдэх аюултай.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн хэвийн үйл ажиллагааг саармагжуулах, улмаар улс төрийн нөлөөнд хялбархан автах, цаашилбал Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг улс төрийн зорилгоор эгүүлэн татах, огцруулах нөхцөл бий болж, Үндсэн хуулийн цэцийн хуулийн хүрээнд явуулах тогтвортой үйл ажиллагаа алдагдаж улмаар Үндсэн хуулийн цэц орших уу, эс орших уу гэсэн эрх зүйн хямралд хүргэх аюултай юм.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү



Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, 3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг тус тус зөрчсөн эсэх тухай хянан хэлэлцэж, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэсэн байна.

***Хоёр. Монгол Улсын Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сэргэлэн Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:***

“... 1.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны зорилт нь Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж, магадлан шийдвэрлэж Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгааг хангахад оршино.” гэж заасан.

Үндсэн хуулийн цэцэд иргэн, албан тушаалтны өргөдөл, мэдээлэл, хүсэлтээр маргаан үүсэх эсэхийг шийдвэрлэх ажиллагаа нь хянан шалгах ажиллагааны чухал үе шат бөгөөд энэ үе шатанд гаргах гишүүний шийдвэр нь хууль зүйн үндэслэлтэй байх, Үндсэн хууль зөрчсөн байж болзошгүй үндэслэл бүхий гомдол, мэдээллийг маргаан үүсэх шатанд хэрэгсэхгүй болгохоос, түүнчлэн маргагч талуудын хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх хууль зүйн боломжит бүхий л хамгаалалт, зохицуулалтыг бий болгохыг чухалчилдаг.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хууль зөрчсөн тухай иргэнээс гаргасан өргөдөл, мэдээллийг хүлээн авсан гишүүн анхны шалгалтыг 14 хоногийн дотор хийж маргаан үүсгэх эсэхийг өөрийн санаачилгаар шийдвэрлэнэ.” гэж заасан нь Цэцийн гишүүнд хэрэг маргааныг бие даан шийдвэрлэх эрх мэдэл олгож байгаа хэдий ч нөгөө талаас Цэцэд маргаан үүсгэх эсэх асуудлыг дангаараа шийдвэрлэх, гишүүний үзэмжээс шалтгаалан асуудалд субъектив хандах, ойролцоо буюу нэг ижил төрлийн өргөдөл, мэдээллээр маргаан үүсэх эсэх асуудлаар гишүүд өөрт хуваарилсан өргөдөл, мэдээлэлд ялгаатай байр суурь илэрхийлж, шийдвэрлэсэн байх, ингэснээр Цэцийн үйл ажиллагааны нэгдмэл байдлыг алдагдуулах боломжийг бүрдүүлж болзошгүй.

Хувь гишүүний хувьд шийдвэр гаргахад өөрийн үнэт зүйл, мэргэжилдээ үнэнч байж итгэл үнэмшилдээ захирагддаг хэдий ч бусад гишүүн нь үзэл бодол, дотоод итгэл үнэмшилээр асуудалд өөрөөр хандах, улмаар саналын зөрүү үүсэх тохиолдолд түүнийг харилцан зөвшилцөж ойлгох, ардчиллын зарчмаар буюу олонхоор шийдвэр гаргах нь маргааныг бүх талаас нь бүрэн гүйцэд, бодитой хянан үзэж магадлах, үндэслэлтэй

шийдвэр гаргахад чухал үр нөлөөтэй. Хувь санал гаргах боломжтой байх нь гишүүдийн дотоод хараат бус байдал буюу бусад гишүүдийн бие даасан байдлыг хамгаалах бодит илэрхийлэл болно.

2.Цэц Үндсэн хууль зөрчсөн тухай иргэдийн өргөдөл, гомдлын үндэслэлийг гүйцэд шинжлэн судлалгүйгээр “маргаан үүсгэх үндэслэл тогтоогдоогүй” гэсэн үндэслэлээр маргаан үүсгэхээс татгалзах нь Үндсэн хууль зөрчсөн хэм хэмжээ, үйл ажиллагаа нь Цэцээр бүрэн шалгагдахгүйгээр маргаан үүсэх шатанд хэрэгсэхгүй болох боломжийг нээх, ингэснээр Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “... Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих ...” Цэцийн бүрэн эрхэд нийцэж байгаа эсэх асуудал хөндөгдөнө.

Дээрх нөхцөл байдлыг үндэслэн хууль тогтоогч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийг 1997 онд батлан гаргахдаа маргаан үүсэх эсэх талаарх Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талуудын гомдлоор болон Цэцийн өөр гишүүний саналаар Цэцийн бага суудлын хуралдаанаар дахин хянуулах боломжтой байхаар хуульчилсан. Ингэснээр нэг талаас өргөдөл, мэдээлэл гаргагчийн эрхийг хамгаалахын зэрэгцээ Цэц шатлалгүй шүүх учир түүний үйл ажиллагаанд дотоод хяналтыг бий болгож, Цэцийн шийдвэр бодитой, үндэслэлтэй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.Цэцийн гишүүн нь өөрийн дотоод итгэл үнэмшлээр гагцхүү Үндсэн хуульд захирагдаж, шийдвэрээ гаргах бөгөөд харин хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд тухайлбал, маргаан үүсэх эсэх асуудлыг хянан шалгах явцад хөндлөнгөөс оролцох, саналаа хэлэх, зөвлөх зэргээр шийдвэрт нь нөлөөлөх аливаа оролдлого нь түүний хараат бус байдалд халдаж байгаа илрэл болно. Цэцийн гишүүний шийдвэр гаргах үйл явцад бус харин гаргасан шийдвэрт Цэцийн өөр гишүүн санал гаргаж, улмаар Бага суудлын хуралдаанаар эцэслэн шийдвэрлүүлэх нь мэдээлэл гаргагчийн үзсэнчлэн гишүүний хараат бус байдалд халдаж байгаа бус, харин Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлэх зарчим, үзэл санааг хамгаалахад чиглэгджээ.

Тиймээс Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ...” гэж заасан нь Үндсэн хуулийн цэцийн гишүүн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо аливаа этгээдээс хараат бус байж, шударга ёсыг тогтоох, Үндсэн хуулийг хамгаалах, Үндсэн хуульд хэр үнэнч, зарчимч гэдгээ харуулах боломжийг олгосон агуулгаараа хууль дээдлэх ёсонд, Цэцийн гишүүн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх боломж олгосон агуулгаараа Цэцийн гишүүний хараат бус байдлыг алдагдуулах биш, харин бэхжүүлэхэд чиглэгдсэн гэж үзэж байна.



Дээр дурдсаныг үндэслэн Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ..." гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэж үзэж байна." гэжээ.

### **ҮНДЭСЛЭЛ:**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага гэж тодорхойлсон байна. Түүнчлэн Үндсэн хуулийн цэцийн хараат бус байдлыг Үндсэн хуулиар баталгаажуулан, Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.", мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана." гэж тус тус заажээ.

2.Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх зохицуулалтын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн Цэц, түүний гишүүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.", 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... Цэцийн гишүүд эрх тэгш байна." гэж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа Цэцийн гишүүн аливаа байгууллага, албан тушаалтан, бусад иргэнээс хараат бус байж, гагцхүү Үндсэн хуульд захирагдан, дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэнэ.", 2 дахь хэсэгт "Цэцийн гишүүн албан үүргээ гүйцэтгэхдээ аль нэг этгээдийг төлөөлөхгүй.", 3 дахь хэсэгт "Албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнээс маргаан хянан шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно." гэж тус тус хуульчилж, Цэцийн гишүүний Үндсэн хуулиар баталгаажсан хараат бус байдлын баталгааг тогтоосон байна. Тодруулбал, Үндсэн хуулийн цэцийн гишүүд эрх тэгш байж, ямар ч байгууллага, албан тушаалтан, иргэнээс хараат бусаар маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж, зөвхөн Үндсэн хуульд захирагдаж, асуудлыг шийдвэрлэхээр, нөгөө талаас албан тушаалтан, иргэн хэн боловч Цэцийн гишүүнээс маргаан хянан шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, шахалт дарамт үзүүлэх, бусад хэлбэрээр нөлөөлөхийг хориглохоор хуульчилжээ.

3.Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны

тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг урьдчилан шалгаад Үндсэн хуульд захирагдан, дотоод итгэлээрээ асуудлыг шийдвэрлэж гаргасан Үндсэн хуулийн цэцийн гишүүний маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан, эсхүл үүсгэсэн шийдвэрийг адил тэгш эрх бүхий Цэцийн аль нэг гишүүн эс зөвшөөрч, санал бичгээр гаргаж болохоор заасан байна.

Дээрх хуулийн үзэл баримтлал болон хэлэлцэн баталсан Улсын Их Хурлын холбогдох хуралдааны тэмдэглэлээс үзэхэд ийнхүү хуульчилсан үндэслэлийг Үндсэн хуулийн цэцийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг бий болгох зорилготой гэсэн нь олон улсын нийтлэг жишигт нийцээгүй, Үндсэн хуулийн эрх зүйн орчин үеийн номлолд харшилж байна.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэдэг байгууллага болохын хувьд үйл ажиллагааны дотоод хяналтыг бий болгох нь Цэцийн гишүүдийн тэгш эрхийг хөндөж, улмаар хараат бус байдлын баталгааг алдагдуулах нөхцөлийг үүсгэхээр байна.

4.Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи шийдвэрийг эс зөвшөөрч Цэцийн аль нэг гишүүн санал гаргахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Цэцийн гишүүн ... өөрийн санал, дүгнэлтийг ... ямар нэгэн хэлбэрээр урьдчилан илэрхийлэхийг хориглоно.”, түүнчлэн Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцийн гишүүн хянан шалгаж байгаа маргааны талаархи саналаа урьдчилан хэлэх, энэ талаар бусад зөвлөгөө өгөх эрхгүй.” гэж заасантай нийцээгүй, эрх зүйн хувьд маргаантай байдлыг үүсгэж, хууль хоорондын зөрчилдөөнийг бий болгосон байна.

5.Нэгдсэн Үндэстний Байгууллагын 1985 оны “Шүүхийн хараат бус байдлын талаарх суурь зарчим”-ын 2 дугаар зүйлд “Шүүх аливаа хэрэг, маргааныг тал харалгүй, хэний ч нөлөөнд авталгүйгээр нотлох баримтад үндэслэн хуульд нийцүүлэн, хууль бус нөлөөлөл, сэтгэл хөдлөл, дарамт шахалт, шууд болон шууд бус хөндлөнгийн оролцоогүйгээр шийдвэрлэнэ.” гэж, 1983 оны Шүүхийн хараат бус байдлын талаарх Монtréalын түгээмэл тунхаглалын 2.3-т “Шүүгч нь шийдвэр гаргах явцдаа хамт ажилладаг бусад шүүгч, дээд шатны шүүхийн шүүгчдээс хараат бус байна. ...” гэж тус тус заасныг тэмдэглэх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон



## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ НЬ:

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэх талаархи Цэцийн гишүүний шийдвэрийг маргагч талууд буюу Цэцийн аль нэг гишүүн эс зөвшөөрч гомдол, санал бичгээр гаргасан бол Цэцийн даргын тогтоолоор томилсон 3 гишүүний бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан хэлэлцэж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэх эсэхийг шийдвэрлэж магадлал гаргана.” гэж заасны “... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ...” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... тэгш байдал ...-г хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “... буюу Цэцийн аль нэг гишүүн ..., санал ...” гэсэн заалтыг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2021 оны 5 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

3. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Монгол Улсын Их Хуралд уламжилсугай.

**ДАРГАЛАГЧ**

**Д.ОДБАЯР**

**ГИШҮҮД**

**Д.СОЛОНГО  
Г.ТУУЛХҮҮ  
Ш.СОЛОНГО  
Г.БАЯСГАЛАН**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

**Утас:** 262420

Хэвлэлийн хуудас: 2

**Индекс: 200003**